ЦАХИМ ХӨГЖИЛ, ИННОВАЦ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЯАМ, ТҮҮНИЙ ХАРЬЯА БАЙГУУЛЛАГЫН 2025 ОНЫ “ЁС ЗҮЙ, САХИЛГА ХАРИУЦЛАГЫН ҮНЭЛГЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ”-ИЙН ТАЙЛАН

Нэг. Товч танилцуулга

Засгийн газрын бүтцийн тухай, Засгийн газрын бүрэлдэхүүний тухай, Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд 2021 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр нэмэлт, өөрчлөлт орж, Цахим хөгжил, харилцаа холбооны яам анх байгуулагдсан бол дээрх хуулиудад 2025 оны 07 дугаар сарын 10-ны өдөр орсон нэмэлт, өөрчлөлтөөр Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам болж өөрчлөгдөн зохион байгуулагдсан.

Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын эрхлэх асуудлын хүрээнд Харилцаа холбооны тухай, Шуудангийн тухай, Радио долгионы тухай, Өргөн нэвтрүүлгийн тухай, Цахим гарын үсгийн тухай, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай, Кибер аюулгүй байдлын тухай, Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай, Инновацийн тухай хуульд заасан онцлог бүрэн эрх, чиг үүргийг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам болон харьяа байгууллагууд болох Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар, Радио телевизийн үндэсний сүлжээ УТҮГ, И-Монгол академи УТҮГ, Үндэсний Дата төв УТҮГ, Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх нийтийн төв УТҮГ хамтран хэрэгжүүлж байна.

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн 07 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны орон тоог **89**, Засгийн газрын 2025 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн 52 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын орон тоог **51**, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2024 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн А/04 дүгээр тушаалаар Үндэсний Дата төв УТҮГ-ын орон тоог **86**, 2024 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн А/31 дүгээр тушаалаар И-Монгол академи УТҮГ-ын орон тоог **125**, 2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн А/15 дугаар тушаалаар Радио телевизийн үндэсний сүлжээ УТҮГ-ын орон тоог **214**, 2025 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн А/137 дугаар тушаалаар Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх нийтийн төв УТҮГ-ын орон тоог **47** байхаар тус тус баталсан байдаг.

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Ёс зүйн хорооны 2024 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн 05 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Ёс зүйн дэд хорооны ажиллах журам”-ын 2.4-д заасныг баримтлан яамны Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн А/126 дугаар тушаалаар яамны Ёс зүйн дэд хороог 7 хүний бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн байгуулсан.

Тайлант онд яамны дэд хорооны 2 гишүүн ажлаас чөлөөлөгдсөнтэй холбогдуулан орон гарсан 2 орон тоог нөхөх зорилгоор яамны албан хаагчдын дунд

санал асуулга явуулж, олонхын санал авсан 2 албан хаагчийг чөлөөлөгдсөн албан хаагчийн үлдсэн хугацаагаар нөхөн сонгосныг Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн А/77 дугаар тушаалаар баталгаажуулсан.

Дэд хорооны нарийн бичгийн даргын ачааллыг тэнцвэржүүлэх зорилгоор ажлын хэсгийн гишүүд улирлаар ээлжлэн нарийн бичгийн даргын үүргийг гүйцэтгэж байна.

Яамны харьяа байгууллагуудын Дэд хороо дараах бүрэлдэхүүнтэй ажиллаж байна:

1. Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын Ёс зүйн дэд хороог 2025 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн газрын даргын А/24 дүгээр тушаалаар 7 албан хаагчийн бүрэлдэхүүнтэй байгуулсан.
2. “И-Монгол академи” УТҮГ-ын Ёс зүйн дэд хороог 2024 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн захирлын А/106 дугаар тушаалаар 7 албан хаагчийн бүрэлдэхүүнтэй байгуулсан.
3. “Үндэсний дата төв” УТҮГ-ын Ёс зүйн дэд хороог 2025 оны 11 дугаар сарын 14 -ны өдрийн захирлын А/89 дугаар тушаалаар 5 албан хаагчийн бүрэлдэхүүнтэй байгуулсан.
4. “Радио, телевизийн үндэсний сүлжээ” УТҮГ-ын Ёс зүйн дэд хороог 2025 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн захирлын А/17 дугаар тушаалаар 7 албан хаагчийн бүрэлдэхүүнтэй байгуулсан.
5. “Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх нийтийн төв” УТҮГ-ын Ёс зүйн дэд хороог 2025 оны 12 дугаар сарын 31-ны өдрийн захирлын А/71 дугаар тушаалаар 5 албан хаагчийн бүрэлдэхүүнтэй байгуулсан.

Хоёр.Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн тогтоомжийн хэрэгжилтийн талаар

2.1.“Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн хэрэгжилт:

Үндэсний хөтөлбөрийн “Зорилт 1.1.Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийг бууруулах замаар зөрчлөөс урьдчилан сэргийлнэ.” чиглэлээр дараах арга хэмжээг зохион байгуулан ажиллаж байна.

Тус яамны зохион байгуулалтын бүтэц, албан тушаалын нэрс өөрчлөгдсөнтэй холбогдуулан Төрийн албаны зөвлөлөөс яамны 9 удирдах, 65 гүйцэтгэх албан тушаалын тодорхойлолтыг 2025 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн хуралдаанаараа хянаж батлах зөвшөөрөл олгосны дагуу Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн А/305, А/306, А/307 дугаар тушаалаар баталсан нийт 73 албан тушаалаас тайлант онд ажиллаж байгаа 60 албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийг тооцох үнэлгээг Ёс зүйн хорооноос

баталсан аргачлалын дагуу хийж гүйцэтгэсэн. Үнэлгээгээр тус яамны албан хаагчдын дийлэнх “бага эрсдэлтэй буюу эрсдэлийн нөлөө бага” гэсэн үр дүн гарсан.

Ёс зүйн хорооны 2025 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн 08 дугаар тогтоолоор баталсан “Ёс зүйн зөрчил, хариуцлагын бүртгэлийн хуудас”-ыг хөтөлж, албан хаагчийн хувийн хэргийн бүрдэлд хавсаргах болсон талаар нийт албан хаагчдад албаны цахим шуудангаар мэдээлэл хүргүүлсэн.

Харьяа байгууллагуудад албан тушаалын эрсдэлийг тооцох үнэлгээг аргачлалын дагуу хийхийг чиглэл болгоод байна.

*Үндэсний хөтөлбөрийн “*Зорилт 1.2.Ёс зүйтэй иргэдээр төрийн албаны хүний нөөцийг бүрдүүлэх тогтолцоог хөгжүүлнэ.”, “Зорилт 4.3.Ёс зүйн чиглэлээр хөндлөнгийн хяналтыг хөхиүлэн дэмжинэ.” *чиглэлээр дараах арга хэмжээг зохион байгуулан ажиллаж байна.*

Албан хаагчийн үйл ажиллагааны гүйцэтгэлийн төлөвлөгөөг үнэлэх хэсэгт албан хаагчдын “Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ”-г нэгжийн даргын болон хамт олны үнэлгээгээр тооцож, албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг дүгнэж байна.

Албан хаагч нэгж хооронд шилжин болон сэлгэн ажиллах, тушаал дэвшихэд ёс зүйн зөрчилд холбогдон шалгагдаж байсан эсэх тодорхойлолтыг Ёс зүйн дэд хорооноос гаргаж хэвшсэн.

*Үндэсний хөтөлбөрийн “*Зорилт 3.3.Төрийн албанд ёс зүйн зөрчлийг мэдээлэх тогтолцоог бүрдүүлж, олон нийтийн хяналтыг идэвхжүүлнэ.” *чиглэлээр дараах арга хэмжээг зохион байгуулан ажиллаж байна.*

Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн А/322 дугаар тушаалаар яамны Хөдөлмөрийн дотоод журмыг шинэчлэн баталсан бөгөөд байгууллагын мэдээллийн самбар, цахим хуудас, сошиал сүлжээнд ажлын байрны бэлгийн дарамтын тухай мэдээлэл, зурагт хуудас, зөвлөмж байршуулах, ажлын байрны бэлгийн дарамтын талаарх гомдол, мэдээлэл хүлээн авах “Ёс зүйн дэд хорооны цахим шуудан”-г ажиллуулах талаарх дотоод зохицуулалтыг хийгээд байна. Мөн Хөдөлмөрийн дотоод журамд хөдөлмөрийн харилцаан дахь ялгаварлан гадуурхалт, ёс зүйн зөрчил болон ажлын байран дахь дарамт (бие махбодын, сэтгэлзүйн, бэлгийн)-д өртсөн, эсвэл энэхүү нөхцөл байдалд орсон хэн нэгнийг мэдсэн албан хаагч нэн даруй гомдол, мэдээллийг Ёс зүйн дэд хороонд бичгээр гаргах зохицуулалтыг нарийвчлан тусгаж, ёс зүйн зөрчилтэй холбоотой мэдээ мэдээлэл хүлээн авах сувгийг гаргасан.

Түүнчлэн хүн, хуулийн этгээдээс яамны болон харьяа байгууллагын албан хаагчийн ёс зүйтэй холбоотой асуудлаар гомдол, мэдээллийг хүлээн авах, бүртгэх албаны 11-330781 утсыг ажиллуулж эхэлсэн.

2.2 Томилох эрх бүхий албан тушаалтны ёс зүйн манлайлал:

Үндэсний хөтөлбөрийн "Зорилт 1.3.Төрийн өндөр болон томилох эрх бүхий албан тушаалтны ёс зүйн манлайллыг төлөвшүүлнэ.", "Зорилт 3.1.Төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжийн биелэлтийг хангах чиглэлээр Ёс зүйн хороог бэхжүүлнэ." *чиглэлээр дараах арга хэмжээг зохион байгуулан ажиллаж байна.*

Байгууллагын удирдлагаас ёс зүйн бодлого, дүрэм, журмын хэрэгжилтийг хангах ажилд бодит хувь нэмэр оруулж, албаны хурал, уулзалтын үеэр албан хаагчдын ёс зүйн хариуцлагыг нэмэгдүүлэх, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр мэдлэг ойлголт өгөх, мөн энэ чиглэлийн үйл ажиллагаа явуулж байгаа албан хаагчдыг тухай бүрд дэмжиж ажиллах чиглэлийг яамны зохион байгуулалтын нэгжийн дарга нар болон харьяа төсөвт байгууллагын захирлуудад чиглэл өгч ажилласан.

Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Хөдөлмөрийн дотоод журмын 8.6-д "Ёс зүйн Дэд хорооны нарийн бичгийн даргад хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 50 хувьтай тэнцэх хэмжээний урамшууллыг сар бүр дарга, гишүүдэд хурал болон бусад арга хэмжээнд оролцсон ирц, идэвх оролцоог харгалзан хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр тооцож, албан тушаалын цалингийн 20 хувьтай тэнцэх хэмжээний үйл ажиллагааны үр дүнгийн урамшууллыг улирал тутамд олгоно." гэж Ёс зүйн дэд хороонд ажиллаж байгаа албан хаагчийг урамшуулах асуудлыг тусган, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Тайлант онд 1,188,000 төгрөгийн урамшууллыг олгосон байна.

Харьяа байгууллагын дэд хорооны гишүүдийг урамшуулах асуудлыг хөдөлмөрийн дотоод хэм хэмжээний актуудад тусгах талаар чиглэл өгсөн.

2.3 Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа:

Үндэсний хөтөлбөрийн "Зорилт 1.4.Ёс зүй, сахилга хариуцлагаар үлгэрлэсэн төрийн байгууллагын соёлыг хэвшүүлнэ.", "Зорилт 2.1.Төрийн албан хаагч ёс зүйтэй ажиллахад дэмжлэг үзүүлэх сургалт, нөлөөллийн ажлыг идэвхжүүлнэ." *чиглэлээр дараах арга хэмжээг зохион байгуулан ажиллаж байна.*

Ёс зүйн зөрчлийн бүртгэл, хяналтын дэд систем (hrm.csc.gov.mn)-д хандах эрх нээлгэж, бүртгэл хийсэн. Мөн тайлант онд гарсан дэд хорооны шийдвэрийг харьяалах дэд хорооны цахим системд хөтөлж, хуульд заасан хугацаанд нийтэлж, ил тод байдлыг ханган ажиллаж байна.

Албан хаагч хууль тогтоомжоор хүлээсэн ёс зүйн нийтлэг хэм хэмжээ, шаардлагыг зөрчсөн эсэх асуудлаар тайлант онд яам болон Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар, Радио телевизийн үндэсний сүлжээ УТҮГ, Үндэсний Дата төв УТҮГ, Кибер халдлага зөрчилтэй тэмцэх нийтийн төв УТҮГ-т гомдол, мэдээлэл ирээгүй байна.

И-Монгол академи УТҮГ-ын Ёс зүйн дэд хороонд 2 гомдол (ажилтны цаг ашиглалтын байдал, ажлын байран дахь зодоон), 1 хүсэлт (ажлын байранд

цахилгаан тамхи хэрэглэж байгааг хориглох) ирүүлснийг холбогдох хууль, журмын дагуу шийдвэрлэж, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар нийт албан хаагчдад мэдээлэл хүргүүлсэн байна. Ёс зүйн дэд хорооноос ирүүлсэн дүгнэлтийг үндэслэн Захирлын 2025 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн Б/12 дугаар, 2025 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн Б/112 дугаар тушаалаар тус тус арга хэмжээ авсан.

Тайлант хугацаанд Ёс зүйн дэд хороод батлагдсан төлөвлөгөөний дагуу тогтмол хуралдаж, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, зөвлөмж өгөх чиглэлээр дараах өдөрлөг, арга хэмжээг зохион байгуулсан. Үүнд:

Монгол Улсын ёс зүйн хороо, Удирдлагын академиас хамтран 2025 оны 05 дугаар сарын 21-23, 27-ны өдрүүдэд зохион байгуулсан “Ёс зүйн сургагч багш бэлтгэх” анхан шатны 32 цагийн багц хөтөлбөрт Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Ёс зүйн дэд хорооны гишүүн Салбарын хяналтын газрын ахлах шинжээч Б.Бүрэнжаргал, Кибер аюулгүй байдлын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах шинжээч М.Оролзод нар хамрагдаж, сургагч багшийн эрх авсан.

Яам болон харьяа үйлдвэрийн газруудын хэмжээнд ажилтан, албан хаагчдыг соён гэгээрүүлэх ажлын хүрээнд 2025 оны 01 дүгээр сарын 20-ны өдөр “Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай”, “Төрийн албан хаагчийн ёс зүйн зарчим”, 2025 оны 02 дугаар сарын 21-ний өдөр “Сэтгэл хөдлөлөө удирдах, өөрийгөө тайвшруулах нь”, 2025 оны 06 дугаар сарын 17-ны өдөр “Ёс зүйн суурь ойлголт”, “Хувь хүний хувийн орон зай”, 2025 оны 12 дугаар сарын 15-ны өдөр “Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомж, Ёс зүйн дэд хорооны зохион байгуулалт, үйл ажиллагаа болон ёс зүйн зөрчил, түүний үр дагавар” сэдвийн хүрээнд тус тус сургалт, хэлэлцүүлгийг нэгдсэн зохион байгуулалттайгаар байгууллага тус бүрдээ зохион байгуулсан.

Жендерийн үндэсний хорооны төлөөлөгчийн оролцоотойгоор жендерийн мэдрэмжтэй ажлын байр, ёс зүйн сургалтыг нийт албан хаагчдад үе шаттай зохион байгуулсан.

Ажлын байрны уур амьсгалыг сайжруулах зорилгоор “Төрийн албан хаагчийн ёс зүй ба Таны ирээдүйн амжилт”, “Эерэг уур амьсгал түгээе” нөлөөллийн аяныг тус тус өрнүүлж, албан хаагчдад мэдлэг ойлголт өгөх тараах хуудсыг тарааж, видео контент бэлтгэн байгууллагын олон нийтийн сүлжээн дэх цахим хуудсаар мэдээлэл бэлтгэсэн.Түүнчлэн 9 удаагийн постер, цахим шуудан, дотоод сүлжээ болон Төрийн байгууллагын дотоод удирдлагын ERP системээр дамжуулан ёс зүй, цахим хэрэглээ, эрүүл орчны талаарх мэдээллийг тогтмол хүргэж ажилласан.

*Үндэсний хөтөлбөрийн “*Зорилт 2.2.Төрийн албан хаагч ёс зүйтэй ажиллах орчин, нөхцөлийг бүрдүүлж, дэмжих арга хэрэгслийг өргөжүүлнэ.” *чиглэлээр дараах арга хэмжээг зохион байгуулан ажиллаж байна.*

И-Монгол академи УТҮГ-ын Ёс зүйн дэд хорооноос ажлын байранд утаат болон электрон тамхи татахгүй байх аяныг зохион байгуулж, дотоод сүлжээгээр

постер түгээх, 20 ширхэг хориглох тэмдэг байршуулж, тогтмол мэдээлэл, анхааруулга хүргэж байна.

Шинээр томилогдсон албан хаагч бүрт (100 хувь) ёс зүйн зааварчилгаа өгч, холбогдох хууль, дүрэм журмыг уншиж танилцах үүрэг өгч ажилласан.

Гурав.Гарсан үр дүн, ололт амжилт

1.Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, түүнийг дагаж гарсан хэм хэмжээний актын хүрээнд хэрэгжүүлж байгаа ажил, арга хэмжээ нь байгууллагын түвшинд ёс зүйн дүрэм, дотоод журмыг мөрдүүлэх, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалт, мэдээллийг тогтмол зохион байгуулах боломжийг бүрдүүлж, ажилтан, албан хаагчдыг ил тод, хариуцлагатай, ашиг сонирхлын зөрчлөөс ангид ажиллах чиглэлээр дотоод хяналт бий болгож байгаа нь бодит үр дүн өгч байна.

2.Төрийн албан хаагчийн хууль дээдлэх, ёс зүйтэй, иргэнд ээлтэй хандлага төлөвшиж, иргэдийн төрд итгэх итгэл нэмэгдэн, төрийн байгууллагын үйл ажиллагааны ил тод байдал, хариуцлага сайжирч байна.

3.Төрийн албан хаагч албан үүргээ шударга, ёс зүйтэй гүйцэтгэж, ашиг сонирхлын зөрчилгүй, сахилга хариуцлагатай ажилласнаар хамт олны итгэл, удирдлагын үнэлэмж нэмэгдэж, төрийн албаны нэр хүндийг хамгаалах, бэхжүүлэхэд өөрийн хувь нэмрийг оруулж байгаа нь чухал ололт, амжилт болж байна.

4.Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомж, дүрэм, журмын хэрэгжилтийг хангах зорилгоор зохион байгуулагддаг “Сургагч багш бэлтгэх” хөтөлбөр нь Ёс зүйн дэд хорооны гишүүдийг мэргэжлийн түвшинд бэлтгэж, хуульд заасан үүрэг, хариуцлагыг үнэн зөвөөр, эерэгээр илүү олон ажилтан, албан хаагчдад таниулах нөхцлийг бүрдүүлж, цаашлаад энэ чиглэлийн үйл ажиллагааг тогтмол зохион байгуулах сэдэл, соёл бий болгох хөшүүргэ болж байна.

5.Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, мэдээлэл түгээх ажлыг улирал тутам байгууллагын дотоод сүлжээгээр тогтмол хүргэж, нийт ажилтнуудыг хамарсан тасралтгүй мэдээллийн урсгал бүрдүүлж байна.

6.Байгууллагын ёс зүйн дүрэм, дотоод журам, холбогдох зааварт нэмэлт өөрчлөлт оруулж, хэрэгжилтийг ханган ажилласнаар ёс зүйн зохицуулалт илүү тодорхой, ойлгомжтой болсон.

7.Ёс зүй, ашиг сонирхлын зөрчил, авлигын эсрэг хууль тогтоомжийн талаар нийт албан хаагчдад тодорхой давтамжтайгаар сургалт зохион байгуулж байгаа нь албан хаагчдын хийх ёстой болон хийх ёсгүй үйлдэл, эс үйлдэхүйг ялган таних боломжийг бүрдүүлж байна.

8.Үндэсний дата төв УТҮГ-ын Ёс зүйн дэд хорооноос байгууллагын аттестатчлалын шалгалтын тестийн агуулгад байгууллагын дотоод журам, ёс зүйн журам, дүрэм, хэм хэмжээг хамарсан мэдлэг шалгах тестийг тусгаж, зохицуулалтыг байгууллагын хөдөлмөрийн дотоод журамдаа тусгасан байгаа нь нийт албан хаагчдын ёс зүйн талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэхэд чухал нөлөө үзүүлж байна.

Дөрөв.Бэрхшээл, түүнийг шийдвэрлэх талаарх санал

1.Ёс зүйн сургалт, соён гэгээрүүлэх арга хэмжээг зохион байгуулахад төсөв, санхүүгийн дэмжлэг хангалтгүй, байгууллагын урсгал зардалд энэ чиглэлээр ажиллахад шаардагдах зардлыг системтэйгээр тусгаагүйгээс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт, сурталчилгааны аян өрнүүлэхэд Ёс зүйн дэд хорооны гишүүд өөрийн нөөц бололцоог дайчлах, албан хаагчдыг татах зорилгоор өөрөөс бага хэмжээний зардал гаргах тохиолдол гарч байна.

2.Ёс зүйн дэд хороо нь аливаа гомдол, мэдээллийг хууль, тогтоомж, дүрэм, журмын хүрээнд хүлээн авч шийдвэрлэж байгаа хэдий ч тухайн асуудал шийдвэрлэгдсэний дараа гомдол, зөрчил гаргасан албан хаагчтай өмнө тогтсон ажлын харилцаанд сөргөөр нөлөөлөх, өөрчлөлт орох эрсдэл өндөр хэвээр байна.

3.Ёс зүйн дэд хорооны гишүүд ажлын ачааллаас хамаарч, үйл ажиллагааг тогтмол зохион байгуулах боломж хомс байх тул Ёс зүйн хорооноос тухайн жилд хэрэгжүүлэх ажлыг нөлөөллийн аян байдлаар нэгдсэн удирдлагаар ханган хугацааны хувьд улс даяар нэгэн зэрэг зохион байгуулах зохион байгуулалтыг хийлгэх шаардлагатай.

4.Ёс зүйн хороо болон холбогдох байгууллагад сургалт авах талаар удаа дараа албан бичгээр хандсан боловч хариу ирээгүй, мөн сургалтын талаарх зар, мэдээлэл тогтмол ирдэггүйгээс сургалтад тухай бүр хамрагдахад хүндрэл учирч байна.

5.Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх мэдээллийг тогтмол хүргэж байгаа боловч албан хаагчдын оролцоо, идэвхийг тогтвортой хадгалах нэмэлт хөшүүрэг шаардлага байна.

6.Ёс зүйн дэд хороод нь өөрийн байгууллагын албан хаагчдаас гаргасан зөрчил, гомдлыг шууд шийдвэрлэх бус, харин харьяалал өөр байгууллагын ёс зүйн дэд хороотой харилцан солилцох, хөндлөнгийн зарчмаар шийдвэрлэдэг тогтолцоонд үе шаттайгаар шилжих шаардлагатай.

Зургаа.Шалгах хэсэг:

- Ёс зүй, сахилга хариуцлагын үнэлгээний шалгуур үзүүлэлт”-ийн дагуу үнэлгээ хийсэн эсэх

- Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн үн дүнгийн- хяналт шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтэл нийцүүлсэн баталсан үйл ажиллагааны төлөвлөгөө
- Байгууллагын 2025 оны Ёс зүйн дэд хорооны хууль тогтоомжийн хэрэгжилтийн тайланг маягтын дагуу бүрэн тайлагнасан эсэх

БАТАЛГААЖУУЛАЛТ:

ЦАХИМ ХӨГЖИЛ, ИННОВАЦ, ХАРИЛЦАА
ХОЛБООНЫ ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Б.МЯГМАРНАРАН

ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ ДАРГА Д.БАТБАЯР
ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА Ч.БОЛОР-ЭРДЭНЭ

ЦАХИМ ХӨГЖИЛ, ИННОВАЦ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЯАМ ТҮҮНИЙ ХАРЪЯА БАЙГУУЛЛАГЫН
2025 ОНЫ "ЁС ЗҮЙ, САХИЛГА ХАРИУЦЛАГЫН ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР
ҮЗҮҮЛЭЛТИЙН ҮНЭЛГЭЭ"

№	Үзүүлэлт	Шалгуур үзүүлэлт		ЦХИХХЯ	ТЦҮЗГ	ҮДТ ҮТҮГ	ИМА ҮТҮГ	КХЗ ТНТ	РТҮС ҮТҮГ	Авбал зохих оноо	Оноо	Хувийн жин
1	2	3		-	-	-	-	-	-	4	5	6
1	Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт (ҮХХ)	Үйл ажиллагааны төлөвлөгөөг шалгуур үзүүлэлттэй нийцүүлэн баталсан эсэх		1	1	1	1	1	1	1	1	10
2		Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийн үнэлгээ хийсэн эсэх		1	0	1	0	0	1	1	0.6	6
3		Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс сэргийлэх соён гэгээрүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлсэн байдал	Ёс зүйн сургалтыг 2-оос доошгүй удаа батлагдсан агуулгын хүрээд зохион байгуулагдсан эсэх	0	0.5	0.5	0.5	0.5	0.5	0.5	0.4	4
			Соён гэгээрүүлэх нөлөөллийн ажил зохион байгуулах байдал	0.5	0.5	0	0.5	0.5	0	0.5	0.4	4
			Ёс зүйн нөлөөллийн мэдүүлэг гаргасан байдал	0.5	0.5	0	0.5	0	0	0.5	0.3	3
			Ёс зүйн зөрчлийн хариуцлагыг бүртгэлийн маягт бөглөсөн байдал	0.5	0.5	0.5	0.5	0.5	0.5	0.5	0.5	50
Хэсгийн хороо				**3.5**	**2.5**	**3**	**3**	**2.5**	**3**	**4**	**3.2**	**32**
4	Томилох эрх бүхий албан тушаалтны	Ёс зүйн дэд хорооны дүгнэлтийг үндэслэн шийдвэр гаргасан (гарсан дүгнэлтийн хувийн жингээр тооцох бөгөөд гомдол ирээгүй бол 1 оноо)		1	1	1	1	1	1	1	1	10

5	ёс зүйн манлайлал (ҮХХ)	Төрийн албан хаагчдын ёс зүйн тухай хуулийг хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайлан зөрчлийн шийдвэрлэлтийг цахим хуудсанд байршуулсан байдал	1	1	1	1	1	1	1	1	10
6		Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа гишүүдийг урамшуулах санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлэсэн байдал	0.5	1	0	0	1	0	1	0.5	5
Хэсгийн хороо			**2.5**	**3**	**2**	**2**	**3**	**2**	**3**	**2.5**	**25**
7	Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа (ЁЗДХ)	Дэд хорооны бүрэлдэхүүн хөдөлгөөнийг бүртгэсэн байдал	1	1	1	1	1	1	1	1	10
8		Төрийн албан хаагчаас ирүүлсэн гомдол, мэдээллийг шийдвэрлэсэн байдал	1	1	1	1	1	1	1	1	10
9		Ёс зүйн зөрчлийн бүртгэл, хяналтын дэд систем дэх дүгнэлт шийдвэрийг бүртгэж тайлагнасан байдал	1	1	1	1	1	1	1	1	10
Хэсгийн хороо			**3**	**3**	**3**	**3**	**3**	**3**	**3**	**3**	**30**
Үнэлгээний нийт оноо, хувь			**9**	**8.5**	**8**	**8**	**8.5**	**8**	**10**	**8.7**	**87**